



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 5/51

Модот

Н.Очирмаад сахилгын шийтгэл ноогдуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66,1, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1 дэх заалт, Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн "Улсын үзлэг зохион байгуулах тухай" 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 8/2533 албан тоотын дагуу Төв комиссын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан "Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалт"-ийг дүгнэх үзүүлэлт, аргачлалын дагуу тус сумын Эрүүл мэндийн төвийн Архив, албан хэрэг хөтлөлт болон байгууллагын зохион байгуулалтыг үзэж дүгнэхэд 54,9 хувь буюу "Хангалтгүй" үнэлэгдсэн тул Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, их эмчийг түр орлон гүйцэтгэгч Н.Очирмааг "Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр хаалттай сануулах" сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Байгуулалтын зохион байгуулалт, Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг баримталж, холбогдох албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, их эмчийг түр орлон гүйцэтгэгч (Н.Очирмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ